



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/193

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рэнчинлхүмбэ сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Рэнчинлхүмбэ сумын шар усны үертэй холбогдуулан гарсан зардалд 5,000,000 (Таван сая) төгрөг, аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр мөрдөгч нар орон нутагт ажиллахтай холбогдуулан гарсан зардалд 980,000 (Есөн зуун наян мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай

2. Дээрх зардлын нийт 5,980,000 (Таван сая есөн зуун наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 1010647